

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Дээд боловсролын салбарын эрх зүйн зохицуулалт, мэдээллийн сан, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн үйл ажиллагааны хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн, Буянтогтох Цэнгүүн

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
1.1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах							
1	Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргуулж, хуулийн хугацаанд тайлагнах	ХАСХОМ мэдүүлсэн албан хаагчийн тоо ХАСУМ мэдүүлсэн албан хаагчийн тоо	281 албан хаагчийн ХАСХОМ-ыг гаргуулж, АТГ-т тайлагнасан.	ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд 100 хувь гаргуулж, АТГ-т зөрчилгүйгээр тайлагнасан байна.	1/ Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах нийт 227 албан хаагчаас Боловсролын ерөнхий газрын 66 албан хаагч, Насан туршийн боловсролын төвийн 42 албан хаагч, Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын 119 албан хаагчийн жагсаалтыг Авлигатай тэмцэх газар руу 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 01/188 тоот албан бичгээр хүргүүлж,	1-р сар, 2-р сар	100%

					холбогдох системийг нээлгэсэн. Системд эрхийг нээлгэсний дагуу нийт 227 албан хаагч хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаа буюу 2 дугаар сарын 15-ны өдөр бүрэн мэдүүлж, түүний хураангуй болон дэлгэрэнгүй тайланг системээс татан авч тайланг баталгаажуулан Авлигатай тэмцэх газар луу 2025 оны 02 дугаар 28-ны өдрийн 01/854 тоот албан бичгээр илгээсэн болно. 2/ 2025 оны хагас жилийн байдлаар Авлигын эсрэг хуулийн дагуу харьяалагдах Боловсролын ерөнхий газар, Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага, Насан туршийн суралцахуйн төвийн нийт 48 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг нээж, Авлигатай тэмцэх газраар ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэхийг хянуулсан. 3/ 2025 оны хагас жилийн байдлаар Авлигын эсрэг хуулийн дагуу харьяалагдах Боловсролын ерөнхий		
--	--	--	--	--	--	--	--

					газар, Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага, Насан туршийн суралцахуйн төвийн нийт 20 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд нээж, цахимаар баталгаажуулсан. Хавсралт: 4 файл		
2	Авлигатай тэмцэх газраас батлан гаргасан төлөвлөгөөнд нийцүүлэн Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангах, тайлагнах	Гүйцэтгэлийн хувь	2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг 98 хувь гүйцэтгэлтэй тайлагнасан.	Авлигатай тэмцэх газраас батлан гаргасан төлөвлөгөөнд нийцүүлэн Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж, хугацаанд нь тайлагнасан байна.	1/ Авлигатай тэмцэх газрын боловсролын асуудал хариуцсан комиссарын ирүүлсэн төлөвлөгөөний саналыг үндэслэн Боловсролын ерөнхий газрын даргаар 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөр "Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө"-г батлуулсан. Тус төлөвлөгөөгөөр нийт 3 зорилтын хүрээнд 16 арга хэмжээг төлөвлөж, Авлигатай тэмцэх газрын "Авлигын эсрэг үндэсний сүлжээ" цахим платформ (khutulbur.iaac.mn) системд 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдөр системийн эрх нээгдэхээр биелэлтийг тайлагнахаар бэлтгэл ажлыг хангаж байна. 2025 оны 06 дугаар сарын 05-ны	6-р сар, 12-р сар	100%

					өдрийн байдлаар 16 арга хэмжээнээс хагас жилийн байдлаар тайлагнах 12 арга хэмжээ байгаа бөгөөд нийт биелэлт 99.1 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд: 1/ 11 арга хэмжээ 100 хувь, 2/ 1 арга хэмжээ 90 хувьтай биелэлттэй байна. /Хавсралтаар хагас жилийн биелэлтийн 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн байдлаарх биелэлтийн гүйцэтгэлийг оруулав/ Хавсралт: 1 файл		
3	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс баталсан үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, тайлагнах	Гүйцэтгэлийн хувь	2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг 96 хувь гүйцэтгэлтэй тайлагнасан.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс баталсан үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж хугацаанд нь тайлагнасан байна.	Хүн худалдаалахтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжигдсэн "Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө"-нд Боловсролын ерөнхий газар үндсэн хэрэгжүүлэхээр ажиллах 1 арга хэмжээний биелэлтийг гарган, 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн дотор Гэмт хэргээс урьдчилан	6-р сар, 12-р сар	100%

					сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд хүргүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. /Хавсралтаар тайланг хавсаргав/ Хавсралт: 2 файл		
4	Авлигатай тэмцэх газраас баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-өөс боловсролын салбарт хамаарах үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах, тайлагнах /АТҮХХАХТ-6.4.11.1/	Гүйцэтгэлийн хувь	-	2024 оны Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг заасан хугацаанд тайлагнаж, 2025 оны Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хамаарах арга хэмжээний дагуу үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	1/ 2024 оны Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг Монгол Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 46 дугаар тогтоолын 2 дахь хэсэгт зааснаар "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг тогтоосон хугацаанд хэрэгжүүлж, хэрэгжилтийг жил бүрийн 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Авлигатай тэмцэх газарт тайлагнаж ажиллахыг даалгасан байдаг." Тус тогтоолын дагуу Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсанаар Боловсролын ерөнхий газарт холбогдох 8	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

				зорилт, 11 арга хэмжээний биелэлтийг Khutulbur.iaac.mn буюу Авлигын эсрэг үндэсний сүлжээ сайтад 2025 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн дотор цахимаар бүрэн тайлагнаж, баталгаажуулсан. /Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 08/8631 дугаартай "Үнэлгээний дүнг хүргүүлэх тухай" албан бичгийг хавсаргав/ Авлигатай тэмцэх газрын "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх" хэлтсээс тайлагналтыг үнэлсний үндсэн дээр 50 оноотогоор Засгийн газрын нийт 26 агентлаг хамрагдсанаас 7 дугаар байранд эрэмблэгдсэн байна. 2/ Авлигатай тэмцэх газраас 2025 оны 05 дугаар сарын 14-ны өдрийн 08/9304 дугаартай "Хамтран ажиллах тухай" албан бичгээр Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2025 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийн		
--	--	--	--	--	--	--

					явцыг 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн дотор системд оруулах шаардлагын дагуу явцын тайланг 10 арга хэмжээний хүрээнд системд бүрэн тайлагнасан. /Хавсралтаар системийн зургыг нотломжоор оруулав/ Хавсралт: 2 файл		
--	--	--	--	--	--	--	--

1.2. Байгууллагыг шүүхэд төлөөлөх

5	Өөрийн чиг үүрэгт хамааралтай асуудлаар итгэмжлэлийн үндсэн дээр байгууллагыг шүүхэд төлөөлөх	Шүүхэд төлөөлсөн тоо	Боловсролын ерөнхий газарт холбогдох нийт 4 шүүх хуралд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдон шүүхэд төлөөлсөн.	Байгууллагын итгэмжлэлийн үндсэн дээр шүүхэд төлөөлөн шаардлагатай баримт бичгийг бүрдүүлэн ажилласан байна.	2025 оны хагас жилийн байдлаар нийт 2 захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд Боловсролын ерөнхий газрыг шүүхэд төлөөлөн ажиллаж байна. Үүнд: 1. "Манагал" ХХК-ийн нэхэмжлэлтэй Боловсролын ерөнхий газарт холбогдох захиргааны хэргийн маргаанд 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 01/1476 дугаартай албан бичгээр итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдож, тус хэрэгт холбогдох нийт 3 удаагийн шүүх хуралд оролцсон. Эхний шүүх хурал нэхэмжлэгч талаас нэхэмжлэлийн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
---	---	----------------------	---	--	--	---	------

					шаардлагаа нэмэгдүүлсэн тул хойшлуулсан, хоёр дахь шүүх хурлаар томилолтой давхцсан тул шүүх хурал хойшлуулах хүсэлтийг гаргасан, гурав дахь шүүх хурал нэхэмжлэгч талаас шинжээч томилуулах хүсэлт гаргасан тул шүүхээс хүсэлтийг хүлээн авч тус хэргийг Захиргааны ерөнхий хуулийн 65.1.7 дахь заалтад заасны дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлсэн. Тус хурлаас хойш нийт 6 удаа Мөнхбаатар шүүгчийн туслахтай холбогдож, шүүх хурлын тов гарахыг асууж лавлах үйл ажиллагааг хийж байгаа бөгөөд шинжээчээс шүүх шинжилгээний дүгнэлт албан ёсоор ирээгүй гэдэг үндэслэлээр шүүх хуралдаан зарлагдахгүй нөхцөл байдал үүссэн байна. 2/ Боловсролын ерөнхий газраас "Си Би Аутсорс" ХХК-д холбогдуулан Ховд аймаг дахь сум дундын иргэний хэргийн шүүхэд 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 1/552 дугаартай албан бичгээр нэхэмжлэл		
--	--	--	--	--	---	--	--

					гаргасан. Нэхэмжлэлийг 2025 оны 04 дүгээр сарын 14-ны өдөр Ховд аймаг дахь сум дундын иргэний хэргийн шүүх хүлээн авч, хариуцагчид гардуулсан. 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр шүүх хуралдаан товлогдон зарлагдаж, хариуцагч өмгөөлөгчтэй оролцох, нэхэмжлэгч тал буюу Боловсролын ерөнхий газрын Хөрөнгө оруулалтын хэрэгжилт, зохицуулалтын мэргэжилтэн итгэмжлэгдсэн төлөөлөгч томилолтоор явсан тул заавал шүүх хуралдаанд оролцуулах хүсэлт гарсны дагуу тодорхойгүй хугацаагаар хойшилсон. Хавсралт: 4 файл		
6	Шаардлагатай тохиолдолд хууль хяналтын байгууллагад Боловсролын ерөнхий газрыг төлөөлж ажиллах	Хууль, хяналтын байгууллагыг төлөөлж ажилласан тоо	-	Боловсролын ерөнхий газрыг шаардлагатай тохиолдолд хууль хяналтын байгууллагад тухай бүр төлөөлөн шаардлагатай баримт бичгийг бүрдүүлэн ажилласан байна.	Авлигатай тэмцэх газраас Нийслэлийн ерөнхий боловсролын 40 дүгээр сургуулийн захирал Б.Балганд холбогдох эрүүгийн хэргийн мөрдөн шалгах ажиллагаанд 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 1/1169 албан бичгээр итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон. 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					Мөрдөн шалгах хэлтсийн мөрдөгч, комиссар Б.Банзрагчтай холбогдож, хэргийн материалтай танилцаж, хохирогч, иргэний нэхэмжлэгчээр тогтоох шийдвэртэй танилцаж, гарын үсэг зурсан. Хавсралт: 1 файл		
3.1. Эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомж, салбарын бодлого шийдвэр, үйл ажиллагааг сурталчлан зохион байгуулах							
7	Өөрийн чиг үүрэгт хамааралтай албан бичиг болон өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх	Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн албан бичгийн болон өргөдөл, гомдлын тоо	47 албан бичгийн хариуг хүргүүлж, 72 албан бичгийн холбогдох хууль тогтоомжийн дагуу гарган хүргүүлсэн.	Өөрийн чиг үүрэгт хамааралтай албан бичиг болон өргөдөл, гомдлыг хууль тогтоомжийн хүрээнд судлан, 100 хувь хариуг хуулийн хугацаанд багтаан хүргүүлж, шийдвэрлэсэн байна.	2025 оны хагас жилийн байдлаар чиг үүргийн дагуу өргөдөл, гомдол хуваарилагдан ирээгүй. Харин бусад төрийн болон төрийн бус, хувийн байгууллагуудаас нийт 22 албан бичиг чиг үүргийн дагуу шилжин ирж, хуулийн хугацаанд холбогдох хариуг өгч, бүрэн шийдвэрлэсэн. Үүнд: 1. Авлигатай тэмцэх газраас - 6 албан бичиг; 2. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас - 1 албан бичиг; 3. Төв аймгийн Боловсролын газраас - 1 албан бичиг; 4. Монгол улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс - 2 албан бичиг; 5. Завхан аймгийн Тосонцэнгэл мэргэжлийн сургалт	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					үйлдвэрлэлийн төвөөс - 3 албан бичиг; 6. Дархан өргөө политехникийн коллежоос - 2 албан бичиг; 7. Баянзүрх дүүргийн цагдаагийн газрын 2-р хэлтсээс - 1 албан бичиг; 8. Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн тамгын газраас - 2 албан бичиг; 9. Адина тэгш боломж Холбоо /НҮТББ/ - 1 албан бичиг; 10. Увс аймгийн Боловсролын газраас - 1 албан бичиг; 11. Монгол шуудан ХХК - 1 албан бичиг; 11. Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар ТБАГ - 1 албан бичиг байна. Мөн чиг үүргийн дагуу 39 бичгийг баримт бичгийн стандартын дагуу төлөвлөн холбогдох байгууллагад хүргүүлэн ажилласан. Хавсралт: 3 файл		
8	Хэрэгжиж буй хууль тогтоомж болон хууль тогтоомжийн төсөлд санал өгөх	Санал өгсөн хууль тогтоомжийн тоо	Нийт 6 хууль тогтоомжийн төсөлд санал өгч ажилласан.	Санал авахаар ирүүлсэн хууль тогтоомжийн төсөлд 100 хувь санал өгсөн байна. Чиг үүргийн хүрээнд хамаарах хууль тогтоомжийг судлан	Монгол улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газраас 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн ХЭГ/1028 дугаартай албан бичгээр "Худалдан авах ажиллагааны тухай хууль"-ийн шинэчилсэн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р	100%

				хэрэгжилтэд тулгамдаж буй асуудлын талаарх саналыг холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлсэн байна.	найруулгын төсөл болон дагалдах бусад хуулийн төсөлд санал авахаар ирүүлсний дагуу 6 саналыг гарган өгсөн. /Хавсралтаар санал өгсөн материалыг хавсаргав/ Хавсралт: 1 файл	сар, 11-р сар, 12-р сар	
9	Дээд боловсролын салбарын үйл ажиллагаатай холбоотой баримт бичгийн төслийг хууль тогтоомжид нийцүүлэн хянах арга хэмжээ авах	Хууль тогтоомжид нийцүүлэн хянасан болон боловсруулсан баримт бичгийн тоо	Нийт 72 А тушаал, 68 Б тушаал, 102 гэрээ, 5 санамж бичгийг хянасан байна.	Дээд боловсролын салбарын үйл ажиллагаатай холбоотой баримт бичгийг хууль тогтоомжид нийцүүлэн 100 хувь хянаж, шаардлагатай тохиолдолд боловсруулан ажилласан байна.	Боловсролын ерөнхий газраас 2025 оны хагас жилийн байдлаар нийт 148 А тушаал, 144 Б тушаал, 119 гэрээ, 5 санамж бичиг гаргасан байна. Үүнээс өөрийн албан тушаалын чиг үүрэг болон удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу нийт 19 А тушаал, 22 Б тушаал, 14 гэрээ, 3 санамж бичгийг хянасан байна.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
10	Боловсролын салбарын албан хаагч, үйлчилгээ авч буй иргэдэд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа болон шинээр батлагдсан хууль тогтоомжийн хүрээнд сургалт зохион байгуулах	Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа болон шинээр батлагдсан хууль тогтоомжийг сурталчлан таниулсан арга хэмжээ, хамрагдсан албан хаагч, иргэдийн тоо	Нийт 17 удаагийн сургалтыг аймаг, нийслэлийн боловсролын газруудад зохион байгуулсан.	Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа болон шинээр батлагдсан хууль тогтоомжийг сурталчлан таниулах ажлыг цахим болон танхимын 8 удаагийн сургалт, 2 удаагийн подкаст бэлтгэн түгээсэн байна.	1/ 2025 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн Насан туршийн суралцахуйн төвийн болон Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын мэдээлэл солилцох уулзалтаар "Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг", "Хөрөнгө орлогын мэдүүлэг болон Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг" гаргахад анхаарах асуудал сэдвийн хүрээнд Насан	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

				туршийн суралцахуйн төвийн нийт 28 захирал, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын нийт 34 захиралд цахимаар сургалт орсон. Сургалтаар захирлууд ямар үе шатанд анхаарах болон хэрхэн албан хаагч нараа ХАСУМ, ХАСХОМ гаргуулах тал дээр мэдлэг мэдээлэлтэй болсон юм. 2/ Боловсролын ерөнхий газар болон Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн комиссар М.Жамъянчойжилтай хамтран нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулийн захирлуудад авлигын гэмт хэрэг сэдвийн хүрээнд 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 16 цаг 00 минутад цахим хэлбэрээр сургалтыг зохион байгуулав. Сургалтад нийслэлийн Ерөнхий боловсролын 157 сургуулийн удирдах ажилтнуудаас 76 удирдах ажилтан хамрагдсан. Мөн сургалтад хамрагдсан албан тушаалтнуудаас 4 асуулгын хүрээнд	
--	--	--	--	--	--

					баталгаа гаргуулан авсан. 3/ Ховд аймагт 2025 оны өдрийн 05 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулсан "Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах ажилтны сургалт-зөвлөгөөн"-д Мэргэжлийн болон техникийн боловсролын салбарын нийтлэг асуудал, ХАСУМ, ХАСХОМ-ийн талаарх сэдэвт сургалтыг нийт 30 захиралд орсон. 4/ 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрөөс 05 дугаар сарын 09-ны өдрийн хооронд Идэр их сургууль, АШУҮИС болон Улаанбаатар эрдэм их сургуулиудад "Авлигыг үл тэвчих, ёс суртахууныг төлөвшүүлэх" агуулгын хүрээнд сургалтын хөтөлбөрт хэрхэн тусгах талаарх хэлэлцүүлэг, уулзалтыг зохион байгуулсан. 5/ 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр Боловсролын ерөнхий газрын "Мэдээлэл солилцох уулзалт"-аар Дүрэм, журмын хэрэгжилт, тушаал шийдвэр боловсруулах, анхаарах	
--	--	--	--	--	---	--

					асуудлууд сэдвээр сургалт орсон. Хавсралт: 3 файл		
11	Боловсролын салбарын албан хаагч, үйлчилгээ авч буй иргэдэд хууль эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх	Хууль эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлсэн байгууллага, албан хаагчдын тоо, хянаж зөвлөсөн баримт бичгийн тоо, албаны болон ХЭЗХ-ийн албан хаагчдын хувийн гар утсаар зөвлөгөө дэмжлэг үзүүлсэн тоо, биечлэн ирж зөвлөгөө дэмжлэг авсан иргэдийн тоо	Нийт 1200 салбарын албан хаагч, үйлчилгээ авч буй иргэдэд хууль эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлсэн.	Боловсролын салбарын албан хаагч, үйлчилгээ авч буй иргэдэд биечлэн болон утсаар холбогдож тухай бүр хууль, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэгийг үзүүлж ажилласан байна.	Боловсролын салбарын албан хаагч, үйлчилгээний авч буй иргэдэд нийт давхардсан тоогоор 521 удаагийн зөвлөгөө дэмжлэгийг өгч ажилласан. Үүнд: 1. Биечлэн зөвлөгөө, мэдээлэл өгсөн - 15 2. Албаны утсаар зөвлөгөө, мэдээлэл өгсөн - 6 3. Хувийн гар утсаар зөвлөгөө мэдээлэл өгсөн - 500 удаагийн зөвлөгөө, мэдээллийг боловсролын салбарын албан хаагч болон үйлчилгээ авч буй иргэдэд өгсөн байна. / албаны утсаар зөвлөгөө өгсөн мэдээллийн нотлох баримтыг хавсралтаар оруулав/ Хавсралт: 3 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
3.2. Хууль тогтоомжийн мэдээллийн сан бүрдүүлэх							
12	Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем дэх "Файлын сан" цэсийг хөтлөх	Цахим хуудсанд байршуулсан мэдээллийн тоо	18	Шинээр батлагдсан болон нэмэлт өөрчлөлт орсон баримт бичгийн мэдээллийг байгууллагын "Файлын сан" цэсэд сар бүр 1-ээс	1/ Боловсролын ерөнхий газрын "Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем"-ийн Файлын сан цэсэд байрлах "Хууль, эрх зүй" хэсэгт нийт ...	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар	80%

				доошгүй мэдээлэл байршуулж, хүчингүй болсон эрх зүйн баримт бичгийг устган, хагас жилийн байдлаар нийт 6 мэдээлийг оруулсан байна.	мэдээлэл байршуулсан. Үүнд: 1. "Салбарын холбогдох дүрэм журам" цэсийн Дээд боловсролын эрх зүйн дүрэм журам хэсэгт 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр "Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчдад тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам"-ыг байршуулсан. 2. "Боловсролын ерөнхий газрын дүрэм, журам, эрх зүйн баримт бичиг" цэсийн БЕГ-аас батлагдсан эрх зүйн баримт бичиг хэсэгт 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдөр "Кибер аюулгүй байдлын журам"-ыг байршуулсан. 3. "Боловсролын ерөнхий газрын дүрэм, журам, эрх зүйн баримт бичиг" цэсийн БЕГ-аас батлагдсан эрх зүйн баримт бичиг хэсэгт 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр "Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө"-г байршуулсан. 4. "Албан хаагчдын уншиж, судлах хууль тогтоомж" цэсэд 2025 оны 06 дугаар сарын 04-ны өдөр "Сурах	сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	
--	--	--	--	---	--	--	--

					бичгийн эх зохиох, санал авах, дүгнэлт гаргуулах үйл ажиллагааны журам"-ыг байршуулсан.		
13	Боловсролын ерөнхий газрын цахим хуудсан дахь "Хууль тогтоомж" цэсийг хөтлөх	- Цахим хуудсанд байршуулсан мэдээллийн тоо - Хандалтын тоо	16 мэдээллийг байршуулж, 5724 хүний хандалтыг авсан байна.	Шинээр батлагдсан болон нэмэлт өөрчлөлт орсон баримт бичгийн мэдээллийг байгууллагын "Хууль тогтоомж" цэсэд сар бүр 1-ээс доошгүй мэдээлэл байршуулж, хүчингүй болсон эрх зүйн баримт бичгийг устган, хагас жилийн байдлаар нийт 6 мэдээллийг оруулсан байна.	Боловсролын ерөнхий газрын үндсэн фэйж хуудас болох Edu.gov.mn сайт хаагдаж, Засгийн газрын хэрэг эрхлэх газраас нийт төрийн болон төрийн өмчит байгууллагын ашиглах Gov.mn сайтыг боловсруулан гаргасан. Иймд өмнөх сайтад байршсан "Хууль тогтоомж" цэсийн "Дээд боловсрол" хэсэгт байршсан нийт 16 төрлийн мэдээллийг шинэ сайт болох Gov.mn сайтын Эрх зүйн хөтөч цонхны "Хууль тогтоомж" цэсэд байрлах "Дээд боловсролтой холбоотой эрх зохицуулалт" хэсэгт хүчингүй болсон эрх зүйн баримт бичгийг устган, нийт 11 төрлийн эрх зүйн баримт бичгүүдийг дахин шинэчлэн байршуулж, түгээн дэлгэрүүлсэн. Мөн өөрийн чиг үүрэгтэй холбоотойгоор Нийтийн албан тушаалтанд холбогдох хориглолт, хязгаарлалтын тухай 12 видео контентыг бэлтгэн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					гаргасан бөгөөд байгууллагын фэйсбүүк хуудсаар дамжуулан түгээн дэлгэрүүлсэн. Тус мэдээллийг "Хууль тогтоомж" цэсэд байршуулан түгээн дэлгэрүүлэхээр ажиллаж байсан боловч 9 дүгээр сар хүртэл сайтын шинэчлэл хийгдэж байна. /Хавсралтаар сайтын болон системийн зураг оруулав/ Хавсралт: 2 файл		
14	Дээд боловсролын сургалтын байгууллагын цахим хуудсанд Боловсролын ерөнхий газрын үндсэн платформын "Хууль тогтоомж" цэсийн "Дээд боловсролын эрх зүй" цэсийг холбуулах, холбогдох мэдээллийг байршуулах	Хууль тогтоомж цэсийн мэдээллийг байршуулсан сургуулийн тоо	-	Төрийн өмчийн 7 Дээд боловсролын сургалтын байгууллагын цахим хуудсанд Боловсролын ерөнхий газрын үндсэн платформын "Хууль тогтоомж" цэсийн "Дээд боловсролын эрх зүй" цэсийг холбуулах, холбогдох мэдээллийг тухай бүр байршуулсан байх ба шаардлагатай тохиолдолд хувийн хэвшлийн дээд боловсролын	Боловсролын ерөнхий газрын үндсэн платформын "Хууль тогтоомж" цэсэд байршуулсан мэдээ, мэдээллийг төрийн өмчийн 7 их, дээд сургуулийн үндсэн фэйж хуудсаар дамжуулан түгээн дэлгэрүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулж байна. Зохион байгуулалтын шатанд Боловсролын ерөнхий газрын үндсэн платформ болох Edu.gov.mn сайт хаагдаж, Засгийн газрын хэрэг эрхлэх газраас гаргасан Gov.mn сайтыг ашиглах болсон. Үүнээс үүдэн шинэ сайтад системийн шинэчлэл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	80%

				сургалтын байгууллагын цахим хуудсанд холбогдох мэдээллийг байршуулсан байна.	хийгдэх ажлууд гарч байгаа бөгөөд 09 дүгээр сараас шинэчилсэн системийн хувилбар гарах тул одоогоор хуучин сайтын мэдээ, мэдээллийг шинэ сайтад оруулах ажил хийгдэж байна. Иймд төрийн өмчийн 5 их, дээд сургуулиудын олон нийттэй харилцах албатай холбогдож, холбогдох мэдээ, мэдээллийг албан ёсны и-мэйл хаягаар дамжуулан цааш түгээн дэлгэрүүлэх ажлыг хийж байна /Хавсралтаар түгээн дэлгэрүүлж буй сургуулиудын мэдээллийг хавсаргав/ Хавсралт: 4 файл		
3.3. Нэгжийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг мөрдөн ажиллаж, байгууллагын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах							
15	Авлигын эсрэг хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх	ХАСХОМ мэдүүлэг /тоо/	ХАСХОМ-ыг 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор мэдүүлсэн.	ХАСХОМ, ХАСУМ-ийг хуулийн хугацаанд нь мэдүүлсэн байна.	1/ Авлигын эсрэг хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд зааснаар Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаа болох 2025 оны 02 дугаар сарын 15-ны	1-р сар, 2-р сар	100%

					өдрийн дотор Боловсролын ерөнхий газрын ЭБАТ-д гаргаж өгсөн.		
16	Хэлтсийн даргаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллах	Биелэлт /хувь/	Хэлтсийн дарга болон удирдлагаас өгсөн нийт 8 үүрэг даалгаврыг 100 хувь хэрэгжилтийг хангаж ажилласан.	Хэлтсийн даргаас өгөгдсөн үүрэг даалгаврыг тухай бүр шаардлагын дагуу хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	2025 оны хагас жилийн хэлтсийн даргаас өгөгдсөн дараах үүрэг даалгаврыг биелүүлж ажилласан. Үүнд: 1/ Хэлтэст хөтлөгдөж байгаа бүртгэлийн жагсаалтыг гаргаж, хариуцах эзнийг тогтоон 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр хэлтсийн даргад танилцуулж, батлуулсан. 2/ 2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр бүх албан хаагчдын болон хэлтсийн төлөвлөгөөг бүрэн оруулж, баталгаажуулсан. 3/ Хууль, эрх зүйн хэлтсийн болон мэргэжилтнүүдийн 1 дгээр улирлын ажлын гүйцэтгэлийн ярилцлагын тэмдэглэлээр өгсөн зөвлөмжийн дагуу биелэлтийн хэрэгжилтийг 2025 оны 04 дугаар сарын 23-ны өдөр даргад танилцуулж ажилласан. 4/ 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр хэлтсийн даргын өгсөн үүрэг даалгаврын дагуу 2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн	1-р сар, 2- р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					"Гашуудлын үеийн дэгийн тухай" 26 дугаар тогтоолын дагуу постер бэлтгэн түгээсэн. 5/ 2025 оны 04 дүгээр сарын 04-ны өдийн хэлтсийн даргаас өгсөн үүрэг даалгаврын дагуу ерөнхий боловсролын сургуулийн захирал, эрхлэгч, багш ажилтнууд, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нарт хичээл сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахдаа Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/545 дугаар тушаалаар батлагдсан "Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрэм", 2023 оны А/569 дүгээр тушаалаар батлагдсан "Хүүхдийн цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм", 2024 оны А/100 дугаар тушаалаар батлагдсан "Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм" болон холбогдох хууль, тогтоомжийг мөрдөн, хүүхдийн эрхийн зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлж ажиллах талаарх зөвлөмжийг		
--	--	--	--	--	--	--	--

					бэлтгэсэн. 6/ Засгийн газрын хэрэг эрхлэх газраас 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн ХЭГ/1028 албан бичгээр ирүүлсэн "Санал авах тухай" хүсэлтийн дагуу Худалдан авах ажиллагааны хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд өгөх саналыг боловсруулсан. 7/ Нийгмийн даатгалын тухай хуулийн 21.22 дахь заалтаар постер бэлтгэн Боловсролын ерөнхий газрын пэйж хуудсаар түгээсэн. 8/ Дээд боловсролын байгууллагын нөхөн бүртгэлтэй холбоотой хурлын тэмдэглэлийг хөтөлсөн. Хавсралт: 5 файл		
17	Архив, албан хэрэг хөтлөлтийн журмыг хэрэгжүүлж, эрхлэх асуудлын чиг үүрэгт хамаарах мэдээ, мэдээлэл, тайлан, холбогдох материалыг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын нэгж болгон хадгалуулах	Хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтын дагуу хүлээлгэн өгөх архивын нэгжийн тоо	Хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтын дагуу 3 архивын нэгжийг хүлээлгэн өгсөн.	Архив, албан хэрэг хөтлөлтийн журмыг хэрэгжүүлж, эрхлэх асуудлын чиг үүрэгт хамаарах 2024 оны мэдээ, мэдээлэл, тайлан, холбогдох материалыг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын нэгж болгон	Архив, албан хэрэг хөтлөлтийн журмын дагуу нийт 3 боть архивын материалыг архивын нэгж болгон Архив, бичиг хэргийн ажилтад 2025 оны 03 дугаар сарын 30-ны өдөр хүлээлгэн өгч, хадгалуулсан. Үүнд: - 2023 оны Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийн баталгааны маягт (216	1-р сар, 2-р сар, 3-р сар	100%

				хадгалуулсан байна.	хуудастай); - 2023 оны Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийн хураангуй, дэлгэрэнгүй тайлан (51 хуудастай) Хавсралт: 1 файл		
--	--	--	--	---------------------	--	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Шихихутуг Их Сургуулийн Эрх зүйн чиглэлээр суралцаж, магистрын зэрэг хамгаалах	“ШИС”-ийн 2025-2026 оны хичээлийн жилд “Хүний хөгжлийн индекс ба сурч боловсрох эрх” магистрын зэрэг горилсон судалгааны ажлаа хийж гүйцэтгэх	Дипломны ажлын судалгааг хийсэн.	Судалгааны ажлыг хамгаалж, эрдмийн зэрэг горилсон байна.	Шихихутуг Их Сургуулийн хууль зүйн ухааны магистрын зэрэг горилох судалгааны ажлаар "Монгол улсын төсвийн тогтвортой байдлын эрх зүйн зохицуулалт: Анхаарах асуудал, шийдвэрлэх арга зам" сэдвээр 2025 оны 05 дугаар сарын 18-ны өдөр жинхэнэ хамгаалалтад орж, хууль зүйн ухааны магистрын зэрэг горилсон.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар	100%
2	Гадаад хэлний	Гадаад хэлний	Гадаад	-	Цахим хэлбэрээр өөрийн гадаад	6-р сар, 7-р	100%

	сургалтад хамрагдах	мэдлэгийг дээшлүүлсэн байна.	хэлний дунд шатны түвшин		хэлний мэдлэгийг дээшлүүлэх сургалтад хамрагдаж гадаадны хэлний мэдлэгээ дээшлүүлж байна. Хавсралт: 2 файл	сар, 8-р сар, 9-р сар, 10- р сар, 11-р сар, 12-р сар	
--	------------------------	---------------------------------	--------------------------------	--	--	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

Дээд боловсролын салбарын эрх зүйн зохицуулалт, мэдээллийн сан, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн үйл ажиллагааны
хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн, Буянтогтох Цэнгүүн /...../ Огноо: